

# Есүс Христийн шавь болох

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

## Загалмайгаа үүрэгтүн

Лук 9:23-ыг уншаад, Аврагчийн шавь нь болоход тавьдаг шаардлагуудыг олж мэд.

- Энэ шүлэг Есүс Христийн жинхэнэ шавь байх талаар юу зааж байна вэ?

Энэ шүлэгт Есүс Христийн үүрсэн биет загалмайг болон Эцэгийнхээ хүслийг биелүүлэхийн төлөө зовж шаналсан шаналлын талаар дурдагддаг. Хэдийгээр биднээс Их Эзэний адилаар биет загалмай үүрэхийг хүсээгүй боловч биднээс хүссэн Тэнгэрлэг Эцэгийн хүслийг хэцүү байсан ч гэсэн биелүүлэх замаар Түүнийг дагахыг хүссэн.

Иосеф Смитийн Орчуулга, Матай 16:26-г (Матай 16:24, зүүлт тайлбар е-д) уншаад мөн загалмайгаа үүрч, Есүс Христийг дагана гэдэг нь бидний хувьд ямар утгатайг олж мэд.

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Улиссэс Соарэс загалмайгаа үүрэх гэдэг нь юу гэсэн үг болохыг ийн тайлбарласан.



Загалмайгаа өөрөө үүрэх хүсэлтэй хүмүүс бурханлаг бусаас, дэлхийн бүх хүсэл тачаалаас татгалзаж, Есүс Христийн зарлигуудыг дагах замаар Түүнийг хайрладаг болохыг бид судраас мэдэж авдаг.

Бурханы хүсэлд харш аливаа зүйлийг хаяж, биднээс өгөөсэй хэмээн хүссэн бүхнийг золиослон, Түүний сургаалыг дагахыг хичээх нь бидэнд Есүс Христийн сайн мэдээний зам дээр үлдэж, бүр зовлон бэрхшээл, бодгалийн сул дорой байдал, нийгмийн дарамт шахалт, Түүний сургаалтай сөргөлдөх дэлхийн гүн ухаантай тулгарах үед ч тэсэж гарахад бидэнд туслах болно. (Улиссэс Соарэс, “Загалмайгаа үүрэгтүн,” *Ensign*, Nov. 2019, 113–114 эсвэл 2019 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 128–129)

- Та амьдралд тань байгаа бурханлаг бус буюу дэлхийн аливаа хүсэл тачаалаас яагаад татгалзах ёстой вэ?
- Бурханлаг бус буюу дэлхийн аливаа хүсэл тачаалаас татгалзах нь загалмайгаа үүрэхтэй юугаараа адилхан байж болох вэ?
- “Загалмайгаа үүрэх” нь хэрхэн танд Есүс Христийн жинхэнэ шавь болоход тусална гэж та бодож байна вэ?

## Амиа аврахын тулд амиа алдах

Лук 9:24–25-ыг уншаад, Их Эзэн Түүний шавь байх талаар юу заасныг олж мэд.

- Есүс Христийн жинхэнэ шавь байх талаар эдгээр шүлэг юу зааж байна вэ?
- Өөрсдийн таалал, хувиа бодсон хүсэлдээ анхаарлаа төвлөрүүлдэг хүмүүс ямар ямар замаар яваандаа амиа “алдана” гэж та нар бодож байна вэ?
- Хэрэв та Есүс Христийн төлөө амиа алдах болбол амиа аварна гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ?

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) Есүс Христийн төлөө амиа алдах гэдэг нь юу гэсэн утгатай болохыг тайлбарласан.



Зөвхөн өөрийнхөө төлөө амьдардаг хүмүүс эцэстээ хатаж хорчидог, зүйрлэвээс амиа алддаг бол бусдад үйлчлэхэд өөрсдийгөө зориулдаг хүмүүс өсөж дэвжин, амиа авардаг билээ. (Томас С.Монсон, “Өнөөдөр би хэн нэгний төлөө юу хийв?” *Ensign*, Nov. 2009, 85 эсвэл 2009 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 97)

- Та нар Есүс Христийн төлөө амьдралаа умартахаар сонгосон хэнийг мэддэг вэ? Энэ шийдвэр нь тэр хүнд хэрхэн нөлөөлсөн бэ?

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН  
СҮМ

- Эдгээр шүлэг дээрх сургаалын дагуу Есүс Христ амьдарч байсны ачаар та ямар ямар арга замаар адислагдсан бэ?

## Анхаарал сарниулах зүйлсээс холдож, шалтаг тоочихоо болих

Лук 9:57–62-ыг уншаад, зарим хүн Аврагчийг дагахын оронд юу хийхийг хүссэн талаар олж мэд.

- Есүс Христийн жинхэнэ шавь байх талаар эдгээр шүлэг юу зааж байна вэ?

Хайртай хүнийхээ үхэлд гашуудахыг эсвэл найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ салах ёс гүйцэтгэх нь буруу гэж Есүс Христ заагаагүй. Оронд нь Тэрээр шавь байхын тулд өгөх ёстой төлөөсийн талаар чухал сургамжийг зааж байсан.

Ерөнхийлөгч Ховард В.Хантэр (1907–1995) Лук 9:62 дээрх анжисны тухай зүйрлэлийг ийн тайлбарласан.



Анжисчин хүн газрыг шулуун хагалахын тулд өмнөх яг нэг тогтсон цэгээсээ хараагаа салгахгүй байх хэрэгтэй. Ингэх нь газрыг

шулуун шан гаргаж хагалахад тусална.

Гэвч хэр зэрэг урагш ахиснаа харахын тулд анжисчин эргэж харах тохиолдолд түүний шулуун замаас хазайх нь нэмэгдэнэ. Ингэвэл шулуун шан муруй болно. . . . Хэрэв бидний эрч хүч өнгөрсөнд биш, харин өмнө байгаа зүйл дээрээ буюу мөнх амьдрал, авралын баяр баясгалан дээр төвлөрвөл бид үүнийг олох нь гарцаагүй. (Howard W. Hunter, "Am I a 'Living' Member?" *Ensign*, May 1987, 17)

- Өнөө үед хүмүүсийн Их Эзэнийг дагахгүй байхыг сонгоход хүргэж болох ямар ямар нийтлэг шалтгаан байдаг вэ?
- Аврагчийн танаас одоо болон ирээдүйд хийхийг хүссэн зүйл дээр та хэрхэн төвлөрсөн хэвээр байж чадах вэ?